



# Цалинг “цахим” хэлбэрээр авах

тохиолдолд шаардагдах зүйл

Ажилтанд зориулав

Хөдөлмөрийн тухай хуульд цалинг бэлнээр олгоно гэж заасан байдаг ч ажилтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд банкны данс руу шилжүүлэн авахыг зөвшөөрдөг. Банкны бэлэн бус гүйлгээг нэмэгдүүлэх хийгээд мөнгөн гуйвуулгын арга хэрэгсэл төрөлжиж байна. Энэ хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор ажилтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын сайдын олгосон эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн ( ●● Рау зэрэг) дансаар цалинг олгох (цалинг цахим хэлбэрээр олгох)-ыг зөвшөөрдөг боллоо.



Цалинг цахим хэлбэрээр олгох системтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл ба Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын сайдын олгосон эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч (эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч)-ийн талаар ЭМХХЯ-ны веб сайт дахь “танилцуулах материал”, “эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч”-ийн жагсаалтаас харна уу.



Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын яамны веб сайт

## 1 Цалинг цахим хэлбэрээр авах талаар

★Энэхүү танилцуулгад өөрийн цалинг цахим хэлбэрээр авах хүсэлтэй ажилтнууд та бүхэн ойлгох, хийх шаардлагатай агуулгыг нэгтгэн тусгасан болно.

- Цалинг цахим хэлбэрээр авахад, тухайн ажилтны ажиллаж буй аж ахуйн нэгж дээр ажил олгогч ба ажилтны хооронд хөдөлмөрийн гэрээ ✳ байгуулсан байх нөхцөлтэй. Мөн ажил олгогч ба ажилтан хоорондын хөдөлмөрийн гэрээнд тус аж ахуйн нэгжийн үйлчилгээ авах боломжтой, эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийг тусгаж өгсөн байна.

✳Ажилтны олонхиос бүрдэх үйлдвэрчний эвлэл байдаг бол тухайн үйлдвэрчний эвлэл, ажилтны олонхиос бүрдэх үйлдвэрчний эвлэл байхгүй тохиолдолд ажилтны олонхийг төлөөлөх этгээд ба ажил олгогч хооронд хөдөлмөрийн гэрээг байгуулна.



Цалингийн цахим систем нэвтрүүлээгүй аж ахуйн нэгжид ажиллаж байгаа иргэд өөрийн цалинг цахим хэлбэрээр авах хүсэлтэй байгаа тохиолдолд, мөн ажил олгогч ба ажилтан хоорондын хөдөлмөрийн гэрээнд, үйлчилгээ авах эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийг тусгаагүй тохиолдолд аж ахуйн нэгжээсээ болон үйлдвэрчний эвлэл зэрэг байгууллагаас зөвлөгөө авна уу.




### Анхаарах зүйлс

- Энэ нь цалингийн цахим систем нэвтрүүлэхийг албадсан хэрэг биш юм. Мөн ажилтан өөрөө хүсээгүй тохиолдолд цалинг урьдын адил банкны данс зэргээр дамжуулан авах боломжтой.
- Цалингийн нэг хэсгийг цахим хэлбэрээр авч, бусдыг нь урьдын адил банкны данс зэргээр авч болно.
- Цалинг цахим хэлбэрээр авах сонголт хийсэн ч дараа нь хүлээн авах арга хэлбэрээ өөрчилж, банкны данс зэргээр авч болно.

## ШААРДЛАГАТАЙ БҮРДҮҮЛЭХ ЗҮЙЛСИЙН ДАРААЛАЛ

- Цахим хэлбэрээр цалин авах хүсэлтэй бол дараах шаардлагатай бүрдүүлэлтийг хийнэ.
  - ① Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний агуулгатай танилцах
  - ② Ажил олгогчтой ганцаарчилж зөвшөөрснөө мэдэгдэх
  - ③ Үйлчилгээ авах хүсэлтээ эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид үйлдэж өгөх



1

### Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний агуулгатай танилцах

- Хөдөлмөрийн гэрээнд тусгасан эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн дотроос аль байгууллагаар үйлчлүүлэхээ судалж үзэцгээе. Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний агуулга ялгаатай байх тул судалж үзэхдээ бүх эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн цахим хуудас зэргээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.
- Мөн хэд хэдэн эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгох боломжтой.

Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн талаар судалж үзэх үед анхаарах гол зүйл

#### ■ Цалин авах дансны хүлээн авах мөнгөний дээд хэмжээ хязгаартай

Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалж хүлээн авах мөнгөний дээд хязгаар харилцан адилгүй байна. Хүлээн авах мөнгөний дээд хязгаараас давсан тохиолдолд илүү гарсан мөнгө нь өөрийн нээсэн банкны хадгаламжийн дансанд (ажилтны урьдчилж өгсөн данс) автоматаар шилжиж орно.

Мөн хадгаламжийн дансанд мөнгө автоматаар татагдаж орох үед үүсэх шимтгэлийг ажилтан өөрөө төлж болзошгүй.

#### ■ Дансны үлдэгдлийг бэлэн мөнгө (данснаас авах) болгох арга болон шимтгэлийн талаар лавлана уу.

АТМ болон банкны данс зэргээс мөнгө авснаар дансны үлдэгдлээ бэлэн мөнгө болгох (авах) боломжтой ба сар бүр нэгээс доошгүй удаа шимтгэлгүйгээр данснаас мөнгө авах боломжтой. Мөн шилжүүлэх данс болон 2 ба түүнээс дээш гүйлгээний шимтгэл нь эрх бүхий эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас шалтгаалж ялгаатай байна.

## 2

### Ажил олгогчтой ганцаарчилж зөвшөөрснөө мэдэгдэх

- Ажил олгогч (мөн эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч)- оос цалинг цахим хэлбэрээр олгоход шаардагдах зүйлийн талаар тайлбар авч мөн ажил олгогчид хандан цалинг цахим хэлбэрээр олгохтой холбоотой өөрийн зөвшөөрлийн бичгийг үйлдэж өгнө. Зөвшөөрлийн бичгийн хамт дараах зүйлсийг ажил олгогчид мэдэгдэх шаардлагатай.
  - (1) Цахим хэлбэрээр авах цалингийн цар хэмжээ ба мөнгөн дүн
  - (2) Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч - (үйлчилгээ)-ийн нэрс болон цалин хүлээж авах дансны мэдээлэл  
( Жишээ: Дансны дугаар, эзэмшигчийн нэр )
  - (3) Олгож эхлэх тохиромжтой хугацаа
  - (4) Банк зэргийн эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн дансны мэдээлэл зэрэг



Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн данс нь “хадгаламж” үүсгэх бус төлбөр төлөх, шилжүүлэг хийх зориулалттай болохыг ойлгосны дээр, өнөөг хүртэлх хэрэгцээндээ үндэслэн төлбөр тооцоонд зарцуулагдах хэмжээгээр мөнгөн дүнгээ тогтооно уу.

## 3

### Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээ авах хүсэлтээ гаргах

- Ажил олгогчид зөвшөөрөл гаргаж өгсний дараа эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн аппликэйшн зэргээр хандаж, цалин олгох цахим систем ашиглах хүсэлтээ гаргана уу. Мөн эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээ авах хүсэлт гаргасны дараа ажилт олгогчдоо хандаж энэ тухайгаа мэдэгдэх шаардлагатай тохиолдол байдаг.



Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч татан буугдсан үед, дансан дахь үлдэгдлээ яаралтай нөхөж авах боломжтой болохын тулд хүсэлт гаргах үедээ ажилтан ба батлан даалтын байгууллага хооронд **БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ** байгуулна.

### Хийх зүйл дууслаа.

#### Дараачийн хуудсанд тусгагдсан агуулгатай давхар танилцана уу.

Эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалж бүрдүүлэх зүйлс нь ялгаатай байх тохиолдол гарна. Дэлгэрэнгүй мэдээллийг эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын веб сайт зэргээс тодруулна уу.

## 2

### Банкны дансны ШИНЭЧЛЭГДСЭН МЭДЭЭЛЛЭЭ мэдэж байх!

- Урьдчилж нээсэн банкны данс нь эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн дансан дахь үлдэгдэл нь хүлээн авах мөнгөний дээд хязгаараас хэтэрсэн үед тэрхүү илүү гарсан мөнгө автоматаар татагдан орох зориулалтын данс бөгөөд мөн эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч татан буугдсан үед дансны үлдэгдэл нь нөхөж олгогдох ба энэ бол маш чухал зүйл юм. Овог шинэчлэгдэх зэргээр данс эзэмшигчийн нэр өөрчлөгдөх, эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлтэй данс гэрээ цуцлагдахад хүчингүй болох зэрэг тохиолдолд, мөнгө автоматаар татагдаж орох болон нөхөн олгогдоход хугацаа шаардагдах магадлалтай.  
Тиймээс банкны дансны мэдээллээ тогтмол шалгана уу.
- Мөн банкны данс өөрчлөгдсөн тохиолдолд эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэнэ үү.

## 3

### Цалинг цахим хэлбэрээр авахаа болих тохиолдолд болон ажлаа өөрчлөх, ажлаас гарах тохиолдолд

- Ажил олгогчоос гадна эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх шаардлагатай тохиолдол гарна.
- Батлан даалтын байгууллагатай байгуулсан батлан даалтын гэрээ цуцлагдах магадлалтай.  
Гэрээг цуцлахад батлан даалтын байгууллага руу холбоо барьж мэдэгдэх шаардлагатай тохиолдол ч гарна.  
※Дэлгэрэнгүйг эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээс тодруулна уу.

## 4

### ХЭРЭВ ЯМАР НЭГЭН ЗҮЙЛ ТОХИОЛДВОЛ . . .

- **Хууль бус гүйлгээ (өөрөө мэдээгүй байхад зарлага гарсан зэрэг) хийгдсэн тохиолдолд**  
Данс эзэмшигч нь буруугүй бол алдагдсан мөнгө нөхөж олгогдоно. Гэхдээ тодорхой хугацаа-(жишээ: алдагдсаны дараа өдрөөс 30 хоногийн дотор)-ны дотор эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх шаардлагатай.  
Тиймээс хууль бус гүйлгээ хийгдсэн тохиолдолд яаралтай эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээс тодруулна уу.
- **Эрх бүхий эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч нь татан буугдсан тохиолдолд**  
Батлан даалтын байгууллагатай байгуулсан батлан даалтын гэрээнд үндэслэж, дансан дахь үлдэгдэл мөнгө нь даруй нөхөж олгогдоно.  
Мөн нөхөн олголттой холбогдуулан, батлан даалтын байгууллагаас хадгаламжийн дансанд нөхөн олговрыг шилжүүлэх тохиолдол байдаг бол тухайн иргэн нь батлан даалтын байгууллагад нэхэмжлэл гаргах шаардлагатай тохиолдол ч байна.  
※Дэлгэрэнгүйг эрх бүхий мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч болон батлан даалтын байгууллагаас тодруулна уу.



Хүмүүс, Аж амьдрал, Ирээдүйн төлөө  
**Эрүүл мэнд, Хөдөлмөр**  
**Хамгааллын Яам**